

Дүүргийн Засаг даргын оны
.....сарынөдрийн
захирамжийн нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛААР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Налайх дүүргийг хөгжүүлэх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан, эрхэлсэн ажилдаа амжилт, үр бүтээл гаргасан, Налайх дүүрэгт он удаан жил ажиллаж, амьдрахын зэрэгцээ шинэ бүтээл, санал санаачилга гаргасан байгууллага, хүмүүсийг шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Дүүргийн Засаг даргын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэх, өргөн мэдүүлэх, түүнийг хүлээн авч судлан, шийдвэрлэх, шагнал гардуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Дүүргийн Засаг даргын шагнал

2.1. Шагналын төрөл

2.1.1. Дүүргийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжлүүлэхээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барих

2.1.2 Дүүргийн “Хүндэт тэмдэг”

2.1.3 Дүүргийн Засаг даргын “Жуух бичиг”

2.1.4 Дүүргийн Засаг даргын “Баярын бичиг”-ээр байгууллага, иргэнийг шагнаж урамшуулна.

2.2. Дүүргийн Засаг даргын шагналын хийц, загварыг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар батална.

Гурав. Шагналд нэр дэвшигчдэд тавигдах болзол, шаардлага

3.1. Дүүргийн нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжид 10-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан ажилтан, албан хаагч, иргэнийг “Хүндэт тэмдэг”-ээр, 8-аас доошгүй жил ажиллаж хамт олноо ажлын үзүүлэлтээр манлайлагчдыг дүүргийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр, 5-аас доошгүй жил ажиллаж хөдөлмөрийн өндөр амжилт үзүүлсэн ажилтан, албан хаагч, иргэнийг дүүргийн Засаг даргын “Баярын бичиг”-ээр шагнана.

3.2. Дүүргийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан дотоод, гадаадын иргэнд Дүүргийн “Хүндэт тэмдэг”, Засаг даргын “Жуух бичиг”, “Баярын бичиг”-ээр шагнаж болно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, өргөн мэдүүлэх

4.1. Дүүргийн Засаг даргын шагналаар шагнуулах асуудлаар хороо, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага нэр дэвшүүлэн санал гаргана.

4.2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга нар нэр дэвшүүлэх санал гаргаж болно.

4.3 Нэр дэвшсэн байгууллага, ажилтан, иргэдийг хамтын удирдлагын хурлаараа хэлэлцэн тодорхойлолт гаргана.

4.4. Тодорхойлолтод шагналд нэр дэвшигч ямар санаачилга, үр бүтээл гаргасан, дүүргийн хөгжилд оруулсан хувь нэмрийг баримтаар дурьдаж, байгууллагын дарга гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна.

4.5. Шагнуулах нэр дэвшигчийн анкет, тодорхойлолтыг ямар шагналаар шагнуулах саналын хамт албан бичгээр Засаг даргад өргөн мэдүүлнэ.

4.6. Шагналын материалуудыг шагнал гардуулахаас 15-аас доошгүй хоногийн өмнө дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.

4.7. Засаг даргад өргөн мэдүүлсэн тодорхойлолт, анкет болон холбогдох баримт бичгийн бүрдэл, агуулгыг ажлын 5-10 хоногт багтаан судлан санал боловсруулж, шийдвэрийн төслийг Засаг даргад танилцуулна.

Тав. Дүүргийн Засаг даргын шагналаар шагнах асуудлыг шийдвэрлэх, шагнал гардуулах мэдээлэх

5.1. Дүүргийн Засаг даргын шагналаар шагнахад Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ.

5.2. Шагнуулах хүсэлтийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн ажилтан хүлээн авч, дүүргийн Засаг дарга, Тамгын газрын даргад танилцуулан, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн шагналын асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

5.3. Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн шагнуулах тухай тодорхойлолт, дагалдах материалыг нарийвчлан судалж, захирамжийн төсөл боловсруулан холбогдох албан тушаалтнаас санал авч, Засаг даргад танилцуулан шийдвэр гаргуулна. Шагнагдсан иргэдийн талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.

5.4. Дүүргийн Засаг даргын шагнал, тэмдэг, үнэмлэх, дагалдах мөнгөн урамшуулалыг Засаг дарга ёслол төгөлдөр гардуулна. Дүүргийн Засаг даргын шагналыг Засаг даргын даалгавраар Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар гардуулж болно.

5.5. Шагналыг жил бүрийн дүүргийн өдөрлөг наадам, Нийслэлийн өдрөөр тус тус олгоно. Бусад тэмдэглэлт өдрөөр олгож болно.

5.6. Дүүргийн Засаг даргын шагналаар шагнасан, шагнал гардуулсан тухай орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

Зургаа. Шагналыг дагалдах мөнгөн урамшуулал

6.1. Дүүргийн “Хүндэт иргэн” 300.000 төгрөг

6.2. “Дүүргийн хүндэт тэмдэг” 50.000 төгрөг

6.3. Дүүргийн Засаг даргын “Жуух бичиг” 30.000 төгрөг

6.4. Дүүргийн Засаг даргын “Баярын бичиг” 20.000 төгрөг

Долоо. Бусад

7.1. Шагналд зарцуулах хөрөнгийг Засаг даргын Тамгын газрын жил бүрийн төсөвт тусгаж байна.

7.2. Дүүргийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдах асуудал шийдвэрлэгдсэн тохиолдолд тухайн шагналд тодорхойлсон байгууллагаас Засаг даргын Тамгын газрын дансанд тэмдэгний нэг бүрийн үнэ 10.000 төгрөгийг тушаасан байна.

7.3. Шагналд тодорхойлох анкет батлагдсан загвартай байна.

7.4. Шагналыг давхардуулан олгохгүй ба шагнал хоорондын зай 2-оос доошгүй жил байна.


ooo000ooo

Дүүргийн Засаг даргын оны
.....сарынөдрийн
захирамжийн хоёрдугаар хавсралт

ДҮҮРГИЙН ШАГНАЛД ТОДОРХОЙЛОХ АНКЕТ

НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ШАГНУУЛАХААР ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
ХҮНИЙ АНКЕТ

- 1.Эцэг(эх)-ийн нэр:
- 2.Нэр:
- 3.Төрсөн огноо:
- 4.Хүйс:
- 5.Төрсөн аймаг, сум, хот:
- 6.Одоогийн харъяалал:
- 7.Нийгмийн байдал:
- 8.Регистрийн дугаар:
- 9.Боловсрол:
- 10.Ажилладаг салбар:
- 11.Мэргэжил:
- 12.Урьд болон одоо ажиллаж байгаа газар:



№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1			
2			
3			

13.Урьд шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд
1		
2		
3		

14.Шагнуулах үндэслэл:

15.Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:

16.Хамт олны саналын хувь:

Дүүргийн Засаг даргын оны
.....сарынөдрийн
захирамжийн гуравдугаар хавсралт

ДҮҮРГИЙН “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-НИЙ ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР



Дугаар.....

.....
..... таныг

Налайх дүүргийг хөгжүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмрийг өндрөөр үнэлж, дүүргийн Засаг даргын 20..... онысарынөдрийн захирамжаар дүүргийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан тул энэхүү үнэмлэхийг олгов.

Налайх дүүргийн Засаг дарга

(Гарын үсэг, тамга)

Чойжинсамбуугийн РАДНААБАЗАР

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ЖУУХ БИЧИГ”, ЗАСАГ ДАРГЫН “БАЯРЫН БИЧИГ”-ИЙН ЗАГВАР

Дүүргийн Засаг даргын “Жуух бичиг” улаан өнгөтэй, “Баярын бичиг” цэнхэр өнгөтэй хамбан материалтай, В4 хэмжээтэй байна.

Хавтасны гадна талын төв хэсэгт дүүргийн бэлгэ тэмдэг байрлаж, доод хэсэгт “ЖУУХ БИЧИГ”, “БАЯРЫН БИЧИГ” гэж алтан шар үсгээр бичигдэнэ.

Гадна тал



ЖУУХ БИЧИГ



БАЯРЫН БИЧИГ

Дотор тал



Дугаар.....

Эрхэм хүндэт..... танаа

Налайх дүүргээ хөгжүүлэх үйлсэд идэвхтэй оролцож амжилт гаргасныг үнэлж дүүргийн Засаг даргын “ЖУУХ БИЧИГ”-ээр шагнаж мөнгөн урамшуулал олов.

Налайх дүүргийн Засаг дарга

(Гарын үсэг, тамга)

Чойжинсамбуугийн РАДНААБАЗАР

20....оны.....сарын.....өдөр

Дотор тал



Дугаар.....

Эрхэм хүндэт..... танаа

Налайх дүүргээ хөгжүүлэх үйлсэд идэвхтэй оролцож амжилт гаргасныг үнэлж дүүргийн Засаг даргын “БАЯРЫН БИЧИГ”-ээр шагнаж мөнгөн урамшуулал олов.

Налайх дүүргийн Засаг дарга

(Гарын үсэг, тамга)

Чойжинсамбуугийн РАДНААБАЗАР

20....оны.....сарын.....өдөр

